

## ДАЙНЫ ӨМНӨХ ХИЛИЙН БУДЛИАН

*Э.Лувсанбалдан\**

Өнгөрөгч зууны гучаад оны эхээр Японы тал Манжуурыг эзэлснээр бүс нутагт олон улсын байдал түгшүүртэй болж, БНМАУ мөн чанартаа гуравдахь гүрэн Япон улстай хиллэх болов. Тухайн үед Монгол Улсын хил нь түүхэн хугацааны үед төлөвшин тогтож, түүнийгээ хамгаалсаар байлаа.

Гучаад оны дунд үеэс Японы аюул занал Монгол улсын дорнод хилд бодитой нүүрлэж, өдөөн хатгалга нь улс төр, цэрэг, тагнуулын аргаар эрчимтэй өрнөх болсон юм. Монгол улсын төр, засаг нь өөрийн улс орныг бүс нутагтаа цэрэг, стратегийн чухал ач холбогдолтой байгаад дүгнэлт хийж, улс төрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг алдахгүйн тулд дорнод хилийнхээ цагдаа харуулыг байнгын цэргээр халсан билээ. Чингэхдээ БНМАУ нь Японы түрэмгийллийг аль болохоор зайлуулах, Монголын талаас дайн байлдаанд хүргүүлэх аян шалтаг гаргуулахгүй, хилийн цагийн хурцадмал байдлыг зөөлрүүлэх бүх аргыг хэрэглэсэн байна.

1934 оныг хүртэл Японы цэргийн ном хэвлэлд Монгол Улсын хилийг бодит байдлаар тусгаж байсан бол 1935 оноос эхлэн Японы цэргийн командлал, Монгол-Манжгогийн хилийн байр зүйн зургийг дур зоргоор өөрчлөн Манжгогийн хилийг Монгол Улсын хилийн гүн тийш 20 км хүртэл тэлэх болжээ.<sup>1</sup> Үүнийг бид дараах хүчин зүйлтэй холбон үзэж байна. Үүнд:

а. Түүхийн эргэлт нугачааны үед гарч байсан Халх, Баргын нутгийн маргааныг сөхөж, Японы түрэмгийллийг Барга ноёд, иргэдээр талархан дэмжүүлэх.

б. Японы цэргийн эрхтнүүд эзэмшил нутгаа тэлэх, боломж олдвол БНМАУ-ыг эзлэн авах.

в. Тухайн үед БНМАУ-ын хилийг гүнээр хамгаалж байсан Ардын хувьсгалт цэргийн алдааг ашиглахад оршиж байв.

Эдгээрийн дотроос Халх, Баргын газар нутгийн маргаан онцгой чухал байр суурь эзэлж байгаа учир энэ асуудлыг улируулан авч үзэх нь даяаршлын өнөө үед тухайн үйл явдалд улс төр, үзэл суртлаас ангид зөвхөн түүхэн үнэнийг сэргээх, түүхийг шинэ байдлаар харж, судалгааны үр дүнгээ харилцан мэдээлэх, цаашдын хамтын ажиллагааны чиг хандлагыг тогтооход тус дөхөм болно. Үүнтэй уялдуулан Халх, Баргын хилийн асуудлыг хөндөх шаардлага гарч байгаа юм.

а. Халх, Баргын хил хэдүйд, хэрхэн тогтсоныг сөхөж үзвэл одоо бидэнд мэдэгдэж байгаагаар 270 гаруй жилийн тэртээгээс эхэлдэг. Манжуурын Баргууд Халх Монголоос тусгаарлах болсон учир Халхын

\*Э.Лувсанбалдан - Түүхийн ухааны доктор, профессор

Хэрлэн барс хотын чуулганы дарга Сэцэн хан Чойжав, Баргын амбан Загдан нар 1734 онд Халх, Баргын хооронд хил тогтоож Хулд уулын баруун өмнөх Өмхийбулагаас Хэрлэн голын хойт Хавцгайт уул хүртэл, Өмхийбулаг, Номинхан, Бүрд-Овоо, Шилийн худаг, Өвдөг худаг, Бойрын Улаанганга, Булан дэрс, Замын худаг, Модон хашаат, Ар булаг, Енч, Хашаат Хэрлэн голын Хорхойт, Бүрхээр, Зараа уул, Аралт нуур, Хавцгайт уул хэмээх 16 газар хилийн овоо тэмдэг босгосон байдаг.

1848 онд Сэцэн хан Гончигжав, Хөлөнбойрын бүгдийн дарга Дэчин, Намандорж нар Хулд уулаас зүүн өмнө Эрс уул, Хараат уул, Халхын голын өмнө этгээдийн Халуун ам горхины адгийн баруун ууланд овоо тэмдэг босгож хил тогтоосон байна.<sup>2</sup>

Гэвч Баргууд янз бүрийн аргаар нутаг түрж, заримдаа хилийн овоог шилжүүлэн байрлуулдаг жудаггүй явдал гаргасан түүхэн баримт олон бий. Модон хашаат, Ар булагт босгосон хилийн овоонуудыг Мэнэнгийн талын хойт захаас сэм шилжүүлэн тэр их алдарт талын өмнө зах Гурван шавартай хэмээх нууруудын зэргэлдээ байрлуулж байв. Үүнийг Халхууд дургүйцсэнээс 1857 онд Манжийн хаанаас томилогдсон Гирин мужийн жанжин Хинлүн, сөргөлдөгч хоёр этгээдийн түшмэдийг дагуулж, газар дээр нь шалгаад Модон хашаат, Ар булагийн хилийн овоог анхны байранд буцааж тавиулаад улмаар Халхуудын эцэг өвгөдийн шарилыг оршуулдаг Хулд уулыг Халхуудад олгохоор шийдвэрлэсэнээ Манжийн хаанд айлтган зөвшөөрүүлжээ. Эдгээр хэлэлцээрийг зарим хүн төр улсын хоорондын гэрээ бус орон нутгийн чанартай хэмээн чамлах хандлага байдаг. Гэтэл тэр нь Манж чин улсын захиргаанд орчихсон Халх, Барга, Өвөрмонголын засаг хошуудын хооронд урьдах уламжлалаа олон талаас нь харгалзан Манжийн хааны зарлигаар тогтоосон хэлэлцээр, хил байсныг үгүйсгэх аргагүй. Үндэстэн хоорондын энэхүү хилийг зөрчилгүй хамгаалахаар албат ардынхаа нуруун дээр ачаа нэмж зориуд харуул суулгаж байсан нь Монголын хил эрт дээр үеэс тогтсон, түүнийгээ хамгаалах эзэнтэй байсныг нотолно. XIX зууны сүүлчээр Баргууд Манж, Хятадын дарлалд залхаж, Халхуудтай хилийн маргаан гаргахаа зогсож, улмаар нэгдэн нийлэх хандлагатай болжээ. Богд хаант Монгол улсын үед шинэ, хуучин Барга, Үзэмчин зэрэг хошуудын бүгдийн дарга нарын газраас Монголын тусгаар тогтнолыг талархан угтаж, Монголын хаант төрд дагаар орсноо баталж, тамга дарсан бичиг, бэлэг сэлтийг хүргэж иржээ. Ойрмогхон Өвөрмонголын түүхчид “Ар Монголын феодалуудын өдлөгө ба хаант оросын дэмжлэгээр 1912 оны арван хоёрдугаар сард Хөлөнбойр тусгаарлаж, Жавзандамба хааны Ар Монголын “тусгаар төр”-тэй нийлэв”<sup>3</sup> гэж бичсэн нь Баргууд Манж, Хятадын дарлалаас залхаж Монголд нэгдсэнийг одоогийн нөхцөлд

зөөлрүүлэн эмзэглэж, гаднын оролцоо байсан мэт болгон тайлбарласан хэрэг. Ийнхүү Халх, Баргын хооронд гүн зузаан итгэлцэл түр буй болж, хязгаар нутгийн зааг нэгэн үе бүдгэрсэнийг хожмын цагт Баргуудаас өвөлжөө бууц, үхэгсэд, төрөгсдийн нэрийг барьж нутаг булаалцалдах сэжим болон дайны аюулд хүрнэ гэж хэн ч урдаас тааварласангүй.

1919 онд Монголын хаант төр мөхөж, цагаантны генерал атаман Семенов Японоос нууц дэмжлэг авч Барга, Өвөрмонголоос эрчүүдийг цэрэгт дайчлан татаж, Монголтой байлдах отрядыг олноор байгуулсан үеэс Барга ноёдын Монголд итгэх итгэл алдарчээ.

б. Японы тал эх газар дахь эзэмшлээ тэлэх стратегийн тухайд гэвэл: 1927 оны долдугаар сард эзэн хаанаар батлуулсан “Меморандум” хэмээх баримт бичигт “Япон улс Ази тивийг колончлохын тулд юуны урьд Манжуур, Монголыг эзлэн авч цэрэг дайны түшиц газар болгох, тэнд дайны аюулын гайхамшигийг үзүүлэх болно” хэмээн тэмдэглэжээ.<sup>4</sup> Баримт бичгийн заалтыг хэрэгжүүлэхээр 1931 онд Манжуурыг эзэлж Манж-го (1932-1945) гэгчийг байгуулсан юм.

Японы үндэсний батлан хамгаалах судлалын хүрээлэнгийн профессор Хиромицу Шимакобе “...Номунханы хэрэг гарахын яг өмнөхөн Манж, Монголын хилийн шугамын бодит байдал нь Халх голын зүүн талаар гэсэн ойлголт аль алинд нь байсан боловч хоёр тал харилцан зөвшилцөж зураглал хийх аргаар хил тогтоогоогүй бөгөөд тэр тусмаа эцэслэн шийдвэрлэх, өөрөөр хэлбэл улсын хилээ бүрэн тогтоож чадаагүй болно. Гэвч хэрэг гарах эхний үед тухайн газрын батлан хамгаалах удирдлагууд хилийн шугамыг яаж ойлгож байсан, юуг үндэслэн хайгуул шинжилгээний ангийг илгээж байсан юм бол? Түүнчлэн энэ асуудалд Квантуны арми болон хуурай замын цэргийн төв командлалын хандах хандлага зөв эсэх нь тодорхойгүй байна”<sup>5</sup> гэж тэмдэглэжээ. Энэ бол талууд хилээ бүрэн тогтоогоогүйгээс Японы цэргийн командлал Монголын хилд халдсаныг эргэлзээ төрүүлсэн хэмээн нотлох гэсэн санаа мөн.

Гэтэл Монголын дорнод хил нь XVIII зууны дунд үеэс Халх, Баргын тал харилцан тогтоосон тодорхой акт бичиг, газар нутгийн зураг, дээд газрын шийдвэртэй байлаа. Япон эрдэмтэн Хиромицу “...хуурай замын цэргийн төв командлал нь үйл ажиллагааг өргөжүүлэхгүй байх чиг шугамаас хазайж, улсын хилийн голлох маргаантай субъект болсон Халх голын зүүн талын түүхэн хилийн шугамын асуудлыг дипломат яриа хэлэлцээрээр шийдвэрлэхээр оруулаагүйгээс гадна улс төр, стратегийн нэгдмэл нөхцөлийг харгалзахгүй цэргийн хүчийг оруулах нь ямаршуухан аюултай болохыг сайн ойлгоогүй, шуудхан цэргийн хүчийг илгээхээр шийдвэрлэсэн байна”<sup>6</sup> гэж дүгнэсэн нь үнэнд нийцэж байгаа юм.

Японы тал чухам ямар учир шалтгааны улмаас БНМАУ-ын хил рүү өнгөлзөх болсныг нотлох өөр нэг баримтыг Барга ноёд БНМАУ-тай зах нийлсэн нутгийн үнэн байдлыг гуйвуулан 11 зүйлтэй илтгэл бичиж, Квантуны армийн командлалд өргөсөнтэй уялдуулан үзэж болно.<sup>7</sup> Илтгэлийн агуулга нь шинэ Баргын занги Доржжавын ууган хүү улсын түшмэл Далангууд овогтой Гүүвэрийн (1831-1890) Халх, Баргын хилийн тухай бичсэн өгүүллийг иш үндэс болгосон байх магадлалтай. Гүүвэр дорнод Монголын Мэнэнгийн талыг Баргад нэгтгэхийг чармайж байсан түшмэл билээ. Түүний бичсэн өгүүлэлд “Манай шинэ Баргачууд дээд үеийн настангаас аваад эдүгээ болтол үе улиран энэхүү Мэнэн тал дор өвөл цас ормогц нутагладаг байжээ. Ийнхүү манай өвгөд дээдэс зуу гаруй жилийн турш хүйтэн сэрүүнийг энэ нутагт өнгөрүүлэхдээ өвөг настанд ясаа мөн энэхүү Мэнэн тал дор орхиж оршуулсан нь тоогүй болой. Манай хөвгүүд ач нар эдүгээ болтол дээдсийн газраа эзэлж, цагт нийлүүлэн тахиж тайхаа огт тасалдуулсангүй” гээд Манжийн хааны зарлигаар томилогдсон түшмэл, сайд нар Мэнэнгийн талыг Халхад олгосныг ихэд зэмлэн буруушаасан байдаг. Тэрээр цааш нь бичихдээ: Мэнэн талыг Халхад олгосноор “...манай шинэ Баргачуудын өвлийн улиралд нутаглах газар ил бодитой явцуудаж, ялангуяа бидний өвөг дээдсийн яс тавьсан газраасаа ингэж хэзээ үүрд хагацан ангижрах дор хүрвэл манай шинэ Баргын үе үеийн үр ач нар хүртэл үүрд мөрөөдөн санах ба хорсон заных сэтгэл цаглашгүй үлдэх болмуй” гэжээ.<sup>8</sup> Гүүвэр Халхын сүмийг Халхын нутаг мөн хэмээх цохон тэмдэглэсэн мөртлөө Халхын голын зүүн хэсэг газрыг Баргад хамааруулахыг нотлох гэсэн санаархлаа орхиогүй юм.

Дашрамд өгүүлэхэд манай өмнөт хөрш Монголын дорнод хэсэгт өдгөө хүртэл шохоорхон бодит байдалд үл нийцэх мэдээлэл байн байн цацаж байдгийг дурдахад Японы судлаачдад илүүдэхгүй болов уу. 1993 онд хэвлэгдсэн “БНХАУ-ын хил” хэмээх номын III бүлэг буюу “БНХАУ-БНМАУ-ын хил” хэмээх хэсэгт 1962 онд БНХАУ нь БНМАУ-тай 2400 км газраар хил тогтоосон гэжээ. Энэ нь техникийн алдаа бус, үлдэж байгаа 2276,6 км урт тухайлбал дорнод болон өмнөт хэсгийн хилийн шугам нь эдрээтэй хэсэг хэмээн үзсэн утга санаа гэж судлаачийн хувьд үздэг юм.

Гүүвэрийн тооцоолсончлон Квантуны армийн командлагч нь хилийн шугамыг Халхын гол гэж үзэж байжээ. Японы цэргийн Ерөнхий штабын Оросын хэлтсийн ажилтан, Монголын талаар нэвтэрхий мэдээлэлтэй Яно Мицужичи улсын хилийг Халхын гол гэж тодорхойлж байсан удаатай ч Алс дорнодын олон улсын цэргийн шүүхийн хуралд үүнийг гэрчилж чадаагүй юм. 1936 онд Квантуны армийн штабын дарга Итагаки, элчин сайд Аритатай ярилцахдаа “Өөрийн мэдэлд буй бүх арга хэрэгслийг ашиглан Япон-Манжуурын ноёрхолыг Ар монголд

тархаан тогтооход армийн зорилго оршино” гэсэн байдаг.<sup>9</sup> Японы цэргийн эрхтнүүд эзэмшил нутгаа тэлэхийг зорьсон хоёр дахь хүчин зүйлийн тойм иймэрхүү дүр төрхтэй байжээ.

в. Ардын хувьсгалт цэрэг хил хамгаалж байсан үеийг товчхон хөндвөөс.

БНМАУ-ын дорнод хилийг 1933-1938 он хүртэл Ардын хувьсгалт цэрэг хамгаалан дайсагнагч этгээдээс манай оронд шургалан орж дээрэм тонуул хийх, улсын хилийг гааль, зөвшөөрөлгүй нэвтэрч дамын худалдаа үйлдэх зэргийг таслан зогсоож, цэрэг зэвсгийн хүчээр түрэмгийлэл үйлдэгчдэд цохилт өгч байв. Улсын хилийг хамгаалахад МАХЦ-ийн байгуулсан гавъяа их юм. Үүнийг нотлох нэг баримт бол Японы тал Өвөрмонголд хэрэглэсэн аргын адил улсын хил хамгаалж байгаа цэргийн анги, нэгтгэлүүдээ гүн тийш татахыг Монголын талаас шаардаж байсанд оршино.

Гэвч МАХЦ хилийг ихэвчлэн гүнээр хамгаалж, торгон хил эзгүйрч байсан нь харь улсын зүгээс Монголын нутагт айл мал оруулах, орон байшин байгуулах зэргээр газар нутгийн маргаан гаргах бас нэг нөхцлийг бүрдүүлсэн байна. Жишээ нь: 1930 оны арванхоёрдугаар сард Тамсагбулагийн II ангийн төлөөлөгч Батбаяраас “Тус Халх Нөмрөгийн хошууны нутаг болбаас зүүн ба зүүн урагш Баруун Үзэмчин лугаа зах нийлсэн. Дархансөөг, Сүмбэр, Амгалант, Цагаан эрэг, Нөмрөг, Нарийн хоолой, Бичигт, Арбулаг, Галбартай, Зонхи завсрын булаг, Сангийн далай зэрэг харуулууд цөм хил хязгаараас дотогш нэг буюу 2-3 өртөө (25-90 км) хиртэй зайтай газар суурьшсанаас гадна хоорондоо хол...” гэж бичжээ.<sup>10</sup> Ийм нөхцөл байдлын дунд Нөмрөгийн гол, Мана уул зэргэмжийн газарт харийнхан мод огтолж эхэлсэнээ тухайн нутаг хамгаалалтгүй болсон үед зам гүүр тавьж байшин сууц барьжээ.

Газрын зураг ялангуяа хил орчмын зургийг гадаадынхнаар үйлдүүлэхэд нутгийн ардын хүчийг зөв зохион байгуулан ашиглаагүйгээс газрын нэрийг өөрчилж будлиантуулах ноцтой дутагдал жанжин штабын үйл ажиллагаанд олонтой гардаг байлаа. Жишээ нь: Соёлз уулаас дотогш 16 км-ийн гүнд байгаа Тэмээн уулыг Соёлз гэж бичээд хаалтанд Тэмээн уул гэсэн байдаг.

Эдгээр хүчин зүйл нь Японы талаас Монгол Улсын хилийг өдөөн хатгах аян шалтаг болсон байна. Эрдэмтэн Б.Цэдэн-Иш “Япон нь Халхын голын зүүн этгээдийн 1000 гаруй ам км хэмжээний бүх нутаг ба Мэнэнгийн талын хойт хэсгийн 2000 гаруй ам км бүгд 4000 шахам ам км хамгийн сайхан ус ургамал бэлчээртэй, хэн ч хэзээ ч тэдэнд зөвшөөрөхгүй энэ нутгийг таслан авах гэсэн нь үнэндээ дайн түрэмгийлэл явуулахын шалтаг болсон” хэмээн дүгнэсэн байдаг.<sup>11</sup>

Зэвсэгт өдөөн хатгалгын тухайд гэвэл: 1935 оны нэгдүгээр сарын 19-нд БНМАУ-ын Халхын сүмийн хойт талаар Японы талын зэвсэглэсэн хүмүүс хил нэвтэрснийг манай харуулын цэргүүд буцаажээ. Мөн сарын 24-нд Япон-Манжгогийн 17 цэрэг Халхын сүм орчмоор дахин хил зөрчин орж ирсэн байна. Энэ үед 6 дугаар морьт дивизийн 16 дугаар морьт хорооны штабын дарга Д.Дондов, Монгол загас агнуурын харуулын дарга Лхамсүрэн нар 4 цэргийн хамт хилийн манаа эргэж яваад хил зөрчигчидтэй тулгарчээ. Дондов, Япон-Манжгогийнхнаас улсын хил зөрчсөн шалтгааныг лавлаж, асуудлыг эв зүйгээр зохицуулахыг чармайвч Япон бага дарга “Та нарын өмнө манай Наран улсын цэргийн их хүч байна. Та нар үг дуугүй бууж өг!” хэмээн дээрэнгүй шаардлага тавьжээ. Д.Дондов “Бид хэний ч өмнө бууж өгөхгүй, харин та нар манай нутгаас түргэн зайл!” гэсэнд омог бардам япон бага дарга Д.Дондовыг бууджээ. Даргаа хамгаалж буудалцсан бага дарга Янжавын амийг дайсан эрсдүүлээд хилийн чанадад зугтсан байна.<sup>12</sup> Тулалдааны талбараас Япон цэргийн бага дарга Ши Юо нарын 3 үхдлийн хүүр олдсон аж. Энэ нь БНМАУ-ын нутагт устгагдсан Япон цэргийн анхдагч нь болов.

Эх орныхоо хил хязгаарыг дайсны түрэмгийллээс баатарлагаар өмгөөлөн хамгаалж, амь эрсэдсэн Өвөрхангай аймгийн Төгрөг сумын харьяат Дүгэржавын Дондов, бага дарга Готовын Янжав нарын гавьяа Монгол цэргийн түүхнээ мөнхөрч, нэгэн үе Халхын сүмийн харуулыг Г.Янжавын нэрэмжит, Монгол загасны харуулыг Д.Дондовын нэрэмжит болгосон удаатай.

1935 оны нэгдүгээр сарын 26-нд БНМАУ-ын Засгийн газар Монгол, Манжгогийн хил дээр зэвсэгт мөргөлдөөн болсонтой холбогдуулан мэдэгдэл хийж: Халхын сүм нь Халх Монголчуудын нутаг дэвсгэрт багтаж ирсэн бөгөөд 1921 оноос хойш энэ орчим нь Монгол Улсын нутаг хэвээр хилийн постууд (байнгын харуулууд) гарсаар ирснийг цохон тэмдэглэжээ. Мөн өдрийн 13 цагийн орчим Япон, Манжгогийн цэргүүд манай харуулынханыг эсэргүүцэлгүй ухарсныг ашиглаж Монгол загасны харуулыг эзлэв. Тэгсэн атлаа Япон, Манжгогийн түрэмгийлэгчид Халхын сүм нь Манж улсын харьяат газар байтал БНМАУ-ын Хязгаарын цэргийн ангиуд Манж улсын хилийг давж Манжуурын отряд руу халдан довтлов хэмээн гадаад орнуудын хэвлэл мэдээллийн хэрэгслээр гүтгэн зарлав. Халхын сүм Монголын нутаг гэдгийг саяхан болтол Японы зарим судлаачид ойлгоогүй бололтой.

1993 онд Японы монголч эрдэмтэн С.Ушижима Халхын сүмийн будлиан нь Монголын цэрэг “Халхын голыг гатлан Халхын сүмийг эзэлсэнээс болсон”<sup>13</sup> мэт тайлбарласан нь даан ч гэнэн, түүхэн үнэнд үл нийцэхээр хязгаарлахгүй Японы зүгээс БНМАУ-ын нутаг дэвсгэрт

халдан довтолсон түрэмгийллийг цагаатгахыг чармайсны нэг илрэл юм. С.Ушижима цааш нь “...тэр хүнд бэрх цагт Халхын сүмийг эзлэх тушаалыг штабын дарга Дондовт хэн өгсөн бэ гэдэг асуудал зүй ёсоор гарч ирнэ. Миний бодож байгаагаар дээрх тушаалыг Чойбалсан эсвэл Зөвлөлтийн зөвлөх нар Сталины тушаалаар өгсөн байж болзошгүй” гэсэн нь хэн ч итгэмээргүй, үнэнийг мушгин гуйвуулсан оролдлого даруй мөн.

1697 онд Сэцэнханы залгамжир Пунцаг анх байгуулсан Халхын сүмийг Япончууд довтлон эзэлсэн тэр үеийн зарим байдлыг тодруулбал:

- Хилийн цагийн байдал хурцадсантай холбогдуулан уг сүмийн бурхан тахил, лам хуврагуудыг Тамсагийн сүм дээр нүүлгэж суурьшуулсан.

- Японы тал Монгол, Баргын хилийн зургийг зориуд хуурамчаар өөрчилсөн.

- МАХЦ-ын харуулынхан Халхын сүмийн чанад улсын хилийн торгон шугам дээр хоног тутам очиж хамгаалах үүрэг гүйцэтгэдэггүй, алсаас дурандах төдийгөөр харж хамгаалдагтай холбоотойгоор харийнхан энэ орчим нутгийг хариуцах эзэнгүй гэж ойлгосон бололтой.

- Д.Дондов нарт Халхын сүмийг эзлэх тушаалыг хэн ч өгөөгүй, тэд урьд өдрүүдийн хил зөрчигчдийн ул мөрийг шалгах, хил орчим нутгийг үүргийнхээ ёсоор хянаж явсан ажээ.

Сүүлийн 10 гаруй жил Монгол, Японы эрдэмтэн судлаачид Халхын голын дайны сэдвээр удаа дараа хуралдаж санал бодлоо солилцсоны дүнд Японы судлаачдын дүгнэлт өөрчлөгдөж эхлэв. Токиогийн Гадаад судлалын их сургуулийн профессор Х.Футаки Японы жанжин штаб нь буруу мэдээлэлд тулгуурлан зохиосон газрын зургуудыг засахдаа хойрго хандаж байсан нь Халхын голын дайн үүсэх нэг шалтгаан болсон гэж тэмдэглэснээс үзэхэд сөрөг талын судлаачдын дунд өөрчлөлт орж буйг нотолж байна.

Түүхэн үнэний ул мөр өдгөө хүртэл арилаагүй бөгөөд 1986 онд Халхын сүмийн буйран дээр Халхын голын отрядын улс төрийн хэлтсийн орлогч ахмад Аюушийн Батсайхан (өдгөө бэлтгэл дэд хурандаа), зохиогч бид нар очиход Япон винтовны хонгио, газ эсэргүүцэгчийн агаар шүүтч сав, Япон цэргийн зэвд идэгдсэн дуулгын зарим хэсэг зэрэг олдвор элбэг байсны заримыг тус отрядын “Дайчин алдрын танхим”-ын хөмрөгт үлдээсэн бөлгөө.

1935 оны арваннэгдүгээр сарын 29-ний шөнө Монголын Булан дэрсний (Олон худагийн) харуулыг Япон-Манжгогийнхан цэргийн давуу хүчээр гэнэт дайран довтолж энэхүү заставын 18 хүний амь насыг

хөнөөгөөд гэдрэг буцжээ.<sup>14</sup> Мөн оны арванхоёрдугаар сарын 19-ний өглөө Япон, Манжийн хөнгөн тэрэг, эмнэлгийн машинаас гадна 8 машин цэрэг, 300 орчим морьт цэрэг бүхий пулемёт буунуудаар зэвсэглэсэн анги манай Булан дэрсний харуул руу дахин довтолж тэр заставыг бүсэлж, пулемётын гал нээжээ. Харуулынхан “... аливаа өдөөн хатгах явдалд автахгүйгээр зэвсэгт мөргөлдөөнөөс аль болох аргаар зайлсхийх тухай” ЦЯЯ-ны сайд, бүх цэргийн жанжны тусгай тушаалтай учир буудалцалгүй ухарчээ. Гэтэл Япон, Манжгогийн дайнчид ухарч буй харуулчдыг машинаар хөөж, заставын туслах Содовыг дөрвөн цэргийн хамт амий нь хөнөөж, хэд хэдэн хүнийг шархдуулж, харуулынхны байрлаж байсан гэр гурвыг шатаан, эд хогшил, хүнсний зүйлийг дээрэмдэн 16 цэргийг баривчлан хилийн чанд зайлжээ.<sup>15</sup>

Дээрх өдөөн хатгалгатай уялдуулан 1935 оны арванхоёрдугаар сарын 22-нд БНМАУ-ын Засгийн газраас Манжгогийн ГЯЯ-ны сайдад эсэргүүцэл илэрхийлжээ. Түүнд өгүүлэхдээ “Япон, Манжгогийн ангиудаас БНМАУ-ын хилд урьд хожид сонсогдоогүйгээр халдан довтлох явдлаа цаашид үргэлжлүүлэх гэсэн аливаа оролдлого нь хүнд хохирол учруулна гэдгийг Манжгогийн Засгийн газарт анхааруулахыг манай Засгийн газар үүргээ хэмээн үзэхийн хамт энэ бүхний хариуцлага нь Манжго улс болон эдгээр халдлагад цэрэг нь хамгийн идэвхитэй оролцож байгаа Японы засгийн газарт оногдоно” хэмээн тэмдэглэжээ. Энэ сацуу БНМАУ-ын ЦЯЯ-ны сайд, бүх цэргийн жанжны 70 тоот тушаал гарч, “Өөрсдийн биесийг хамгаалахын тулд энгийн ямар ч эсэргүүцэлгүйгээр ухран зугатах бус харин тэдний урьдаас гал нээж эсэргүүцвээс зохино” хэмээн Дорнод хилийн харуулуудад эрх олгожээ. Чухам энэ үеэс Монголын дорнод хилийг хамгаалагчид дайсны довтолгоог эсэргүүцэн байлдах эрх олж авсан юм.

1935 оны арванхоёрдугаар сарын 24-нд Япон, Манжгогийн тал Булан дэрсний харуул руу дахин цэргийн хүчээр довтлов. Тус харуулын бие бүрэлдэхүүн урьдын адид ухарсангүй, бадрангуй зориг эрмэлзлэлтэй байлдсаны учир “... дайсан этгээдээс 1-ийг алсан ба 3-ыг шархадуулан гэдрэг ухруулжээ”.<sup>16</sup> Харийн түрэмгийлэгчдийн эсрэг эрэлхгээр байлдсан пулемётын буудагч Хорлоо болон харуулын бүрэлдэхүүнд Бүх цэргийн жанжин тушаалаар баяр хүргэж сайшаагаад цаашид МАЦХ бүхнээс “... өөрийн нутагт халдсан дайсныг устгахад эрэлхэг зоригтой, шийдвэртэй ажиллах, хатуу бат нэгдэл, сахилгатай байх, агт морьд зэвсгээ хайрлан хамгаалж, түүнийг эх орон, өөрийгөө хамгаалахад ямагт бэлэн байлга”<sup>17</sup> гэжээ.

1936 он гармагц Япон, Манжгогийн дайнчид БНМАУ-ын хилийг өдөөн хатгах үйл ажиллагаагаа улам өргөжүүлж, мөн оны нэгдүгээр сарын дундуур Япон, Манжгогийн тал манай улсын хилээс 20 шахам



км-ын гүнд Хар нуур орчимд харуулаа байрлуулж, түүнийг дагалдуулан Барга малчдыг түлхэн оруулсан байна. “Правда” сонины 1936 оны 16 (6622) дугаарт нийтэлснийг үзвэл, энэ хэсэгт Манжуураас 30 орчим мухлаг тэрэг бүхий нүүдэлчид Япончуудын тушаал, орон нутгийн Барга удирдагчдын заалтаар Манжгогийн нутаг хэмээн ирсэн гэжээ.

Дайсан этгээдийн өдөөн хатгалгын эсрэг зэвсэг хэрэглэн тэмцэх эрх олсондоо идэвхи зориг нь бадарсан хязгаар хамгаалсан цэргүүд нэгдүгээр сарын 15-ны өглөө нутгийн гүнд нэвтэрсэн Япон Манжгогийн харуулынхантай уулзаж, зэвсэг бүхий долоон хүнийг баривчлан, холбогдох газар шилжүүлээд гадаадын айл өрх, зэр зэвсэггүй цэргүүдийг өөрийн хил хязгаараас хөөн гаргасан байна. Мөн өдөр Япон, Манжгогийн ачааны 10 машин Хар нуурын харуул руу довтолжээ. Тус харуулын Содномдаржаа даргатай салаа, хүч нэмэгдүүлсэн Зөвлөлтийн туслан хамгаалах ангийн хуягт машины дарга Даниев, жолооч Баричевский нар “...дайсан этгээдүүдэд ихээхэн хохирлыг учруулан няцааж чаджээ”.<sup>18</sup> Энэ удаагийн байлдаанд Япон, Манжгогийн 30 шахам хүн алагдаж, шархалсан байна. Нэгдүгээр сарын 28-нд Тамсагийн 6 дугаар дивизийн Булан дэрсний харуулаас зүүн хойш 7 км зайтай Цагаан-Ухаад саргүй шөнийн харанхуйгаар дайсан урагшлан давшихад “Манааны ахлагч Ш.Гонгор, Базарсад нар тэдгээр хил зөрчигчидтэй тулгаран байлдав”.<sup>19</sup> Буудалцаан эхлээд удаагүй байхад харуулаас туслах хүч ирсэнд дайсан ухран зугатжээ. Өглөө болмогц хэргийн газарт үзлэг хийсэнд цагаантны офицерын хүүр, орос винтов тэргүүтэн үлджээ. Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн дөрөвдүгээр хурлаас Шагдарын Гонгорыг Цэргийн гавьяаны нэгдүгээр зэргийн одонгоор шагнаж, хожим нь баатар цол хүртээжээ.

1936 оны хоёрдугаар сарын дундаас дорнод хил дээр Япон, Манжгогийн тал их буу, танк, нисэх онгоц бүхий цэргийн хүчээр шууд довтолж эхлэв. Хоёрдугаар сарын 12-нд Монгол улсын хилээс 7 км гүнд байрласан Булан дэрсний харуул руу Япон, Манжгогийн хориод ачааны машинтай 500-гаад цэрэг, 3 их буу, 40 гаруй пулемёт, 2 нисэх онгоц, 2 танкийн хамтаар довтолсон бөлгөө.<sup>20</sup> Сүнрэв даргатай тус харуулын 100 шахам бүрэлдэхүүн 4 хүнд пулемёт, нэг их бууны хамт дайсны эсрэг хориглон байлджээ. Харуулынхан хүч хэрэгслээр дайснаас дутуу байсан ч бүх төрлийн зэвсгийн галаар эсэргүүцэн, пулемётын гал дор зохион байгуулалттай ухарчээ. Тус харуулд нэмэгдэл хүч болон туслахаар хуягтууд байлдаж буй зурвас дээр 4-5 км хүрэлцэн ирмэгц дайсан ухарсанд манай нэгэн хуягт, салааныхан дарга Сэрээтэрийн командаар мөрдөн хөөж 2 машин цэргийг нь буюдан устгажээ.

Энэ байлдаанд дайсны 100 гаруй хүн алдагдаж, 200 гаруй хүн шархдаж, танк, машин тус бүр хоёр жагсаалаас гарчээ.<sup>21</sup> Манай талаас 1 хүн алагдаж, Хорлоо, Г.Гомбо нарын 7 цэрэг шархалджээ.

1936 оны гуравдугаар сарын 9-нд Монгол улсын хилээс 20 км-ийн гүнд байрладаг Баянхоолойн харуулыг Япон, Манжийн 100 гаруй морьт цэрэг бүслэн пулемётын гал нээж, харуулын бүрэлдэхүүнийг ухруулж, орон барилгыг нь шатаачихаад буцжээ. Мөн сарын 15-нд Баргын 500 орчим цэрэг, хоёр нисэх онгоц, хөнгөн танкуудын дэмжлэгтэйгээр Улаантолгойн худагийн орчмоос Булан дэрсний харуул руу довтолон эзэлжээ.<sup>22</sup> Харуулын цэргүүд хориглон байлдаж, дайсны 10 хүн, хоёр хөнгөн танкийг тус тус устгажээ. Дайсны давуу хүчинд түрэгдэн ухарсан энэ байлдаанд манай харуулынхнаас 15 хүний амь эрсдэж, 20 хүн шархалсан юм. Япончууд манай шархагдагсадыг олзлоод хэрцгийгээр харгислажээ.<sup>23</sup>

Гуравдугаар сарын 29-нд Япон, Манжгогийн ачааны долоо, суудлын нэг машинтай 200 гаруй цэрэг Адаг дулааны (Гауран – Япончуудын өгсөн нэр) чиглэлээр хил зөрчин орж иржээ. Эл мэдээг хүлээн авсан жанжин Г.Дэмид, 6 дугаар морьт дивизээс “Р-5” нисэх онгоц 2, хуягт машин 4-ийг Адагдулааны харуулд хүч нэмэгдүүлэн дайсныг устгах тушаал өгчээ. Довтлон ирсэн дайсны эсрэг харуулын дарга Санжаа оновчтой шийдвэр гаргаж, хүчээ зохистойгоор ашиглан, атаклаж таван машины өөдөөс пулемёт, винтовын галаар эсэргүүцсэний дүнд Япон, Манжгогийн нэг машиныг жагсаалаас гаргажээ. Удалгүй Тамсагаас ниссэн Д.Дэмбэрэл, Д.Жамба нарын жолоодсон онгоцууд дайсны автомашиныг жагсаалтаас гаргажээ. Энэ байлдаанд манай талаас хүн хүчний хохирол үзээгүй бөгөөд нисгэгч Д.Жамбаагийн онгоц 29 удаа, Д.Дэмбэрэлийн онгоц 30 удаа суманд өртсөн ч жагсаалаас гаралгүйгээр байлдааныг дуусгажээ.

Монголын дорнод хязгаарын газар нутгийг Япон, Манжгогийн түрэмгийлэгчдээс хамгаалахын төлөө хоёр талаас Халхын голын дайны өмнө хамгийн олон хүн хүч, зэвсэг техник оролцсон байлдаан Адагдулаанд болсон билээ. Гуравдугаар сарын 31-ний өглөө Улаантолгой хавиас Адагдулааныг чиглэн Япон, Манжгогийн цэргийн хоёр хэсэг машины цуваа хөдөлсөн мэдээ Буландэрсний харуулаас дивизэд иржээ. Тэр цуваа 90 гаруй машин, 12 танк, 7 нисэх онгоц бүхий 1000 гаруй хүнээс бүрдсэн нөсөр хүч байв. Удалгүй Адагдулаан, Аршавартайн харуулаас дайсны их хүч айсуу мэдээ ирсэн байна.

Улсын хилийг дайсан их хүчээр цөмөрсөн тухай мэдээг хүлээн авсан Дэмид жанжин (Баянтүмэнд) түүнийг тосч байлдах шийдвэр гаргав. Жанжны шийдвэрээр Баянтүмэнээс нисэх онгоцны нэгдсэн отряд 12 цагт Адагдулаан тийш хөдлөв. Дайсан эхэн үедээ Адагдулааны

харуулыг ухруулж, эсэргүүцэл багатайгаар Монгол нутгийн гүн руу давшиж, Тамсагийн талд байдаг төв зам хүртэл довтлов. Зөвлөлт-Монголын нэгдсэн отрядын 10 нисэх онгоц дайсны цувааг 30 минутын турш бөмбөгдөж, пулемётоор галлах зэргээр есөн удаа амжилттай дайралт хийсний дүнд дайсны бүлэг багагүй хохирол үзэж эмх замбараагүй тарж бутарчээ.

Манай нисгэгчдийн дайралтын дараахан байлдааны талбарт Тамсагаас хөдөлгөсөн маневрийн бүлэг хүрэлцэн ирж дайсныг дайран довтлов. Япон цэргийн машинууд тэр их цасанд дугуйгаа дагнаж, дан дугуйгаа олс буюу гинжээр багласан учир цасанд хий эргэдэггүй, хазгай газарт хальгардаггүй байсныг олзлогдсон машинуудаас манай тал үзэж мэдсэн<sup>24</sup> хэмээн ахмад хилчин Б.Цэдэн-Иш гуайн бичсэн нь Япончуудын техник эзэмших чадамж манайхаас давуу байсныг харуулна. Хуягт сумангуудын араас Зөвлөлтийн пулемётын отряд ирж, дайсны явган цэргийн эсрэг атакт оржээ. Удалгүй моторжуулсан суман, их буунууд ирж байлдаж эхэлжээ. Гэтэл дайсны сөнөөгч болон бөмбөгдөгч онгоцууд манай маневрийн бүлгийн эсрэг дайрч бөмбөгдөн газрын цэргээ хамгаалжээ. Гэсэн хэдий ч онгоцны дайралтууд манай талд төдийлөн хохирол учруулж чадаагүй юм. Харин манай агаарын цохилт, маневрийн бүлгийн довтолгооноос хохирол үзсэн дайсан орой тийш ухарч, байлдааны ажиллагаагаа түр зогсоосон тул Адагдулааны харуул хуучин байраа эзлэн авчээ. Япончууд "...ухрахдаа байлдааны талбарт гэмтэл учирсан манай хөнгөн хуягтыг чирч аваад явсан бөгөөд тэр үед япончуудад байлдааны талбарт эвдэрсэн техникийг чирдэг тусгай машинтай байжээ."<sup>25</sup> Дөрөвдүгээр сарын 1-нээс дайсны газрын цэрэг довтолгоогүй боловч агаарын хүчний дайралт нь идэвхжив. Матадаас хөдөлсөн моторжуулсан отряд (дунд хуягт машинууд) 31-ний орой байлдааны талбарт ойртон ирж, байлдаж байгаа ангиудтайгаа холбоо барьж шийдвэр гаргах гэсэн ч япончууд тэднийг ирснийг мэдмэгц ухарсанаас байлдаанд оролцсонгүй. Энэхүү отряд дөрөвдүгээр сарын 1, 2-ны өдрүүдэд Японы агаарын хүчний дайралтад хэд хэдэн удаа өртсөн ч ноцтой хохирол үзээгүй юм. Адагдулаанд гуравдугаар сарын 29, 30, 31, дөрөвдүгээр сарын эхний өдрүүдэд болсон энэхүү байлдаанд манай талаас 13 хүн амь үрэгдэж, 38 хүн шархдаж, гурван хуягт эвдэрснээс нэг нь дайсанд олзлогджээ.<sup>26</sup> Дайсны талаас 100 гаруй хүн алагдсан гэх боловч тусгай тагнуулын мэдээгээр дөрөвдүгээр сарын 1, 2-ны өдрүүдэд Асар сүмээс Хайлар хот руу үхдэл ачсан машин тав, шархтан ачсан машин гурав, 31-ний байлдаанд дайсны 40 машиныг жагсаалаас гаргаж, танк хоёр, нисэх онгоц нэгийг гэмтээжээ.<sup>27</sup>

Хэдэн хоног үргэлжилсэн Адагдулааны байлдаанд гарамгай гавъяа байгуулсан хүмүүст БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1936 оны дөрөвдүгээр сарын 7-ны 13 дугаар хурлаас төрийн дээд шагнал хүртээжээ. Үүнд: Онцгой гавъяа байгуулсан нисгэгч Дамчайн Дэмбэрэлд “Зоригт баатар” цол, Улаан тугийн 1-р зэргийн одон, Монгол отрядын дарга, нисгэгч Ч.Шагдарсүрэнд улаан тугийн III зэргийн одон “Эрхэм нисгэгч” цол, агаарын бригадын сургагч Судец А.В-г II зэргийн одон (хожим нь БНМАУ-ын баатар), 35 хүнийг Улаан тугийн нэгдүгээр зэргийн одонгоор шагнажээ.<sup>28</sup>

1936 оны гуравдугаар сарын сүүлчээр томхон хүчээр БНМАУ-ын дорнод хилд амжилт муутай халдан довтолсоноос хойш Япон, Манжгогийн цэргийн эрх баригчдаас Монгол Улсын эсрэг шуурхайлан хийсэн түрэмгийлэл юуны учир түр хойшилсон бэ? гэвэл;

а. БНМАУ-ын дорнод хязгаарын хамгаалалт “Тамсагаас цэргээ тат” гэсэн шаардлагаас хойш аль хир бэх бат, найдвартайг бодит байдал дээр мэдэж авсан;

б. Монгол-Зөвлөлтийн хооронд байгуулсан протокол гэрээ түүний хэрэгжилт Японы улс төрийн бодлогод зохих хэмжээгээр нөлөөлсөн;

в. Р.Зорегийн бичсэнчлэн “Гадаад Монголын хилийн хамгаалалттай хаалганд” 1936 онд хийсэн “хүчтэй түрэлт” нь зөвхөн эхний мөргөлдөөнд бут цохигдсон төдийгүй, Японд фашист эргэлт гаргах гэсэн оролдлогоос болж түр хойшилсон;

г. Японы тал Хятадын эсрэг түрэмгий дайнаа эхэлсэн;

д. БНМАУ-ын Засгийн газраас Манжгогийн Засгийн газарт 1936 оны гуравдугаар сарын 31-нд эсэргүүцэл илэрхийлж, түрэмгийллээ зогсоох, асуудлыг хүндрүүлэхгүйн тулд хэлэлцээг даруй сэргээхийг санал болгосонтой холбоотой байлаа.

Адагдулааны мөргөлдөөнөөс хойш БНМАУ, Манжгогийн Манжуурын хэлэлцээг хэзээ хаана дахин сэргээх тухай 1936 оны 3-10 дугаар сар хүртэл нэлээд олон удаа бичиг захидал солилцжээ. Хэлэлцээ эхлэхээс өмнө Манжгогийн тал 1936 оны өвөл болсон тулгаралтад олзолсон хүмүүсээ харилцан солилцох санал тавьсныг Монголын тал хүлээн авсан юм.

1938 оноос Японы тал Барга айлуудыг Монголын хил зөрчүүлэн 10-40 км гүнд нүүлгэн оруулах нь олширсон. 1938 оны арваннэгдүгээр сараас Хайлаастай голын хоёр эргийг дагуулан Баргын мянга шахам өрх айлыг шахан оруулж, өрх бүрд 2-3 цагдаа цэргийг байрлуулж, Монголын нутгаас хөөн гаргахаар очсон хилчдийг эсэргүүцэн бууддаг байв.

1938, 1939 онд БНМАУ-ын хилийг зөрчин ирсэн 479 хүнийг баривчилсний нэлээд нь тагнуулын зорилготой ирснээ хүлээжээ.

Застав, хүч нэмэгдүүлсэн шигшмэл суман хоёр 1939 оны нэгдүгээр сараас тавдугаар сарын 15 хүртэл хамтарсан хүчээр дайсны их, бага нийлсэн бүгд 30 гаруй удаа хил зөрчиж дайрсан дайралтуудыг няцаан тулалдсан байна.

1939 оны Халхын голын зарлаагүй дайны анхны дайралтуудын зүсрэх сум, тэсрэх бөмбөгийн эхний цохилтыг хамгаас урьд Монгол хилчид өөр дээрээ хүлээж авсан билээ.

Япон, Манжгогийн цэргийн командлал, тусгай албаныхан урьд нь бага хүчээр Монгол Улсын хилийн шугамыг удаа дараа зөрчин тагнах, хилийн манааг буудах зэргээр өдөөн хатгадаг байсан бол 1939 оны тавдугаар сарын 11-нээс цэргийн ихээхэн хүчээр манай улсын хилд түрэмгийлэн халдаж Халх голын зарлаагүй дайныг эхэлсэн юм.

Японы тал Монгол Улсын хил орчимд цэргийн хүч, хэрэгслээ бөөгнөрүүлж, Монголын хилийн гүнд цуст мөргөлдөөн байн байн явуулах болсон нөхцөлд БНМАУ албан ёсны харилцаатай цорын ганц орон ЗХУ-ыг түшихээс өөр аргагүй болжээ. ЗХУ-ын цэргийн анги, нэгтгэл БНМАУ-ын тусгаар тогтнолд шийдвэрлэх нөлөө үзүүлсэн төдийгүй, Япон, Манжгогийн өдүүлсэн дайныг 1939 он хүртэл сааруулахад хүргэсэн юм.

Энэ дайны дүнд Монголын дорнод хилийн шугамд ноцтой өөрчлөлт орсон юм. Халх голын отряд Зөвлөлтийн цэргийн тусламжтайгаар Халхын сүмээс Японы цэргийн харуулыг хөөн зайлуулж тэр орчмын 18 мянган га газрыг, Тамсагийн отряд Зөвлөлтийн цэргийн батальоны дэмжлэгтэйгээр Монгол Улсын нутаг Улаан худаг, Хулстайд японоос байгуулсан харуулуудыг бут цохиж Мэнэнгийн их талын 300 мянган га газрыг, наймдугаар сард Монгол, Зөвлөлтийн цэргийн ерөнхий давшилтаар 107 мянган га газрыг чөлөөлж энэ дайнаар бүгд 406 мянган га газар нутгаа харийн дайснаас Монгол буцаан авсан байна.

Гэвч зарим судлаачдын үзэж байгаагаар 200 гаруй жилийн урд тогтоосон хилийн овоо тэмдэгүүдтэй харьцуулан үзэхүл хожим нь үйлдсэн байр зүйн зургийн алдаанаас шалтгаалан Шилийн худагаас Бойрын улаан ганга хүртэл 30 мянган га нутаг, Хулд уулаас Халхын гол хүртэл 21,2 мянган га нутаг тус тус хамгаалалтгүй явж ирсэнээр гадаадынхны харъяанд үлджээ. Энэ зэрэгцээ Монгол-Зөвлөлтийн цэргүүд наймдугаар сарын ерөнхий давшилтаар нэлээд газрын чөлөөлсөн ч фронтын шугам Бүрд овооноос 3 км 700 м наана байхад дайны гал зогссоноос 11,1 мянган га газар нутгаа алджээ.

Дайны дүнд Монголын дорнод хилийн бүгд 114 мянган га газар бусдын мэдэлд үлджээ, 1940 оны зургадугаар сарын 9-ний протоколоор Монгол, Манжгогийн хилийг Нөмрөг голын хойт этгээдийн Амралт

уулаас эхэлж, хойт зүг Бойр нуурын Улаан ганга овоо хүртэл 220 км, хилийн шугамаар овоо тэмдэг тавьж тогтоосон Засгийн газруудын батламж бичгийг 1942 онд Хайлаар хотод солилцсоноор Монголын дорнод хил баталгаажсан юм.

Энэ нь дэлхийн II дайны жилүүдэд Монгол Улс дорно зүгийн хилээ халдашгүй дархан байдлаар хамгаалахад болон хожим нь БНХАУ-тай хил тогтооход эрх зүйн бас нэг үндэс болж өгсөн байна.

Эцэст нь өгүүлэхэд өдгөө Азийн орнуудад тухайлбал Орос, Японы, Япон Солонгос, Хятад БНСУ, Энэтхэг Афганистаны хооронд газар нутгийн маргаан үргэлжилсээр байгаа үед Монгол, Баргын хоорондын нутгийн асуудал дайнаар шувтарч байсны гашуун сургамжыг эргэн дүгнэхэд нь чухал ач холбогдолтой юм.

**ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ**

1. Халхын голын байлдааны түүхэн чухал асуудлууд. УБ. 1989, 45-р тал
2. “Эх орны манаа” сонин. 1990. №2373-2374.
3. Монголын хураангуй түүх. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо. 1988
4. “Үнэн” сонин. 1989. №147, (17364)
5. Халхын голын дайн, орчин үе. УБ. 1999, 43-44-р тал
6. Халхын голын дайн, орчин үе. УБ. 1999, 53-р тал
7. Современная Монголия. Сэтгүүл. УБ. 1932, №5, 24-р тал
8. Олон Монголчуудын уг эхийг тэмдэглэсэн бичиг оршвой. Бээжин. 1989, 393-394-р тал
9. Евгений Качура. Самурай нарын мөрөөр. Москва. 1987, 13-р тал
10. Э.Лувсанбалдан. Халхын голын дайчин хороо. 31-32-р тал
11. Э.Лувсанбалдан. Халхын голын дайчин хороо. 97-р тал
12. Э.Лувсанбалдан. Халхын голын дайчин хороо. 26-р тал
13. Халхын гол: Түүхэн үнэний эрэлд. УБ. 1993, 80-р тал
14. Г.Дэмид. Өгүүлэл, хэлсэн үг. УБ. 1999, 11-р тал
15. ЗХТА. Ф, 1. д, 1. хн, 229
16. Монгол улсын хил хамгаалалтын түүх. УБ. 2008. II боть, 119-р тал
17. ЗХТА. Ф, 1. д, 1. хн, 229
18. Монгол улсын хил хамгаалалтад холбогдох тогтоол шийдвэр. УБ. 1995. I боть, 96-р тал
19. Монгол Улсын хил хамгаалалтад холбогдох тогтоол шийдвэр. I боть. 1995 94-р тал
20. Б.Цэдэн-Иш. Дархан хилийн домогт сургамж. УБ. 1979
21. Монгол улсын хил хамгаалалтад холбогдох тогтоол шийдвэр. УБ. 1995. I боть. 117-р тал
22. ЗХТА. Ф, 1. д, 1. хн, 229
23. ЗХТА. Ф, 1. д, 1. хн, 229
24. Б.Цэдэн-Иш. Дархан хилийн домогт сургамж. УБ. 1979, 92-р тал
25. Б.Цэдэн-Иш. Дархан хилийн домогт сургамж. УБ. 1979, 94-р тал
26. Б.Цэдэн-Иш. Монгол улсын хил хязгаарын бүрэлдэн тогтсон түүхээс. УБ. 1997.
27. Халхын голын байлдааны түүхэн чухал асуудлууд. УБ. 1989
28. Монгол Улсын хил хамгаалалтад холбогдох тогтоол шийдвэр. I боть. 1995 98-99-р тал